



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/364

Номгон

Г Малын хагас жилийн түүвэр судалгаа Г  
явуулах тухай

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 1. 1.г, “Статистикийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 1.в, “Малын индексжүүлсэн даатгалын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 2, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2021 оны хагас жилийн Малын түүвэр судалгааг 2021 оны 06 дугаар сарын 15-22-ны өдрүүдэд зохион байгуулан явуулсугай.

2. Малын түүвэр судалгааны ажлыг зохион байгуулан явуулах комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хяналтын тооллогоор сумдад ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Малын түүвэр судалгааны ажлын бэлтгэлийг коронавируст халдварын хорио цээрийн үеийн халдвар хамгааллын дэглэмийг сайтар хангуулан зохих журмын дагуу, ямар нэгэн зөрчил гаргахгүйгээр зохион байгуулалтын өндөр түвшинд явуулж, хяналт шалгалтын ажлыг чанартай гүйцэтгэн, түүвэр судалгаанд сонгогдсон өрх нэг бүрээр баг, сумын түвшинд цахим програмын дагуу шивж оруулан нэгтгэлийг аймгийн Статистикийн хэлтэст 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Малын түүвэр судалгаанд хамрагдсан өрхийн мэдээлэлд тулгуурлан сумын түвшний нэгтгэл гарч, түүнд үндэслэн даатгалын нөхөн төлбөр олгодог тул мэдээллийн чанар, үнэн бодит байдлыг хангаж, мэдээллийг шивэх явцад гарч болзошгүй алдаа, нөхөн төлбөр олгох явцад гарах маргаан зэргээс урьдчилан сэргийлж, тооллогын ажилд хариуцлагатай хандахыг сумдын холбогдох албан тушаалтнуудад даалгасугай.


5. Малын түүвэр судалгааны ажлыг аргачлал, маягт, заавраар бүрэн хангаж ажиллахыг аймгийн Статистикийн хэлтэс /Х.Ганзориг/-т үүрэг болгосугай.

621010923

2.

6. Малын түүвэр судалгааны ажлыг сумдад коронавируст халдварын хорио цээрийн үеийн халдвар хамгааллын дэглэмийг сайтар мөрдөж зохион байгуулан явуулж дүн нэгтгэлийг гаргаж Үндэсний Статистикийн Хороонд мэдээлэхийг аймгийн комисс (Б.Батсуурь)-т даалгасугай.

7. Малын түүвэр судалгааны ажилд зарцуулахаар 2021 оны төсөвт тусгагдсан 2.000.000 /хоёр сая/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА  Д. МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 06-дугаар  
сарын 07-ны өдрийн А/364 дугаар захирамжийн  
1 дүгээр хэвсрэл



**МАЛЫН ТҮҮВЭР СУДАЛГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ  
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга Б.Батсуурь - Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд Г. Энхбаяр – Аймгийн Засаг даргын орлогч

Ж. Баттөр - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Х. Ганзориг - Статистикийн хэлтсийн дарга

Ч. Эрдэнэбат - Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Ж. Мөнхсоёл – Баянхонгор сумын Засаг дарга

С. Энхтөр – Баацагаан сумын Засаг дарга

Д. Пүрэвсүрэн – Баянбулаг сумын Засаг дарга

Б. Мөнхсайхан – Баянговь сумын Засаг дарга

О. Мөнхбат – Баянлиг сумын Засаг дарга

Ж. Хатанбаатар – Баян-Овоо сумын Засаг дарга

Б. Идэрмөнх – Баян-Өндөр сумын Засаг дарга

Н. Гансүх – Баянцагаан сумын Засаг дарга

Д. Өлзийбаяр – Богд сумын Засаг дарга

М. Мөнхэрдэнэ – Бөмбөгөр сумын Засаг дарга

Д. Лхагвадорж – Бууцагаан сумын Засаг дарга

А. Батбаяр – Галуут сумын Засаг дарга

Б. Гантулга – Гурванбулаг сумын Засаг дарга

Д. Мөнхжаргал – Жаргалант сумын Засаг дарга

Р. Батжаргал – Жинст сумын Засаг дарга

Т. Нямжаргал – Заг сумын Засаг дарга

Т. Эрдэнэбат – Өлзийт сумын Засаг дарга

С. Сумъяабазар – Хүрээмарал сумын Засаг дарга

Н. Сайханбаяр – Шинэжинст сумын Засаг дарга

Д. Цэвэгдорж – Эрдэнэцогт сумын Засаг дарга

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар  
сарын 07-ны өдрийн А/364 дугаар захирамжийн  
2 дугаар хэвсрэлт



**МАЛЫН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ХЯНАЛТААР  
СУМДАД АЖИЛЛАХ ХУВААРЬ**

**Б. Батсуурь** –Аймгийн Засаг даргын орлогч

Баацагаан, Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст

**Г. Энхбаяр** - Аймгийн Засаг даргын орлогч

Галуут, Жаргалант, Заг, Гурванбулаг

**Х. Ганзориг** -Статистикийн хэлтсийн дарга

Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг

**Ж. Баттөр** – ХХААГазрын дарга

Баян-Овоо, Өлзийт, Эрдэнэцогт, Шаргалжуут

**Ч. Эрдэнэбат** – Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Жинст, Богд, Баянлиг, Баянговь

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_